

Банкуудын зээлийн тайлан

2017 оны 5 дугаар сар

Хураангуй мэдээлэл:

- Банкуудын **нийт зээлийн үлдэгдэл 2017 оны 5 дугаар сарын байдлаар 12.6 их наяд төгрөгт** хүрснээс 79.9 хувь төгрөгийн зээл байна.
- **Тайлант сард шинээр 1.3 их наяд төгрөгийн зээл олгогдсоны 78.4 хувь нь төгрөгийн зээл** байна. Харин **1 их наяд 65 тэрбум төгрөгийн зээл төлөгдөв.**
- **Нийт зээлийн 7.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 9.1 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.** Усан хангамж; бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 49.7 хувь, уул уурхай олборлолт 29.2 хувь, боловсруулах үйлдвэрийнх 18.5 хувь, худалдааны салбарынх 10.4 хувьтай байна.
- **Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 60 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 20.1 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 19.9 хувийг 1 жил хүртэлх хугацаатай зээл бүрдүүлж байна.** Харин **нийт олгосон зээлийн 47.4 хувь нь 1 жил хүртэл хугацаатай, 44.2 хувь нь 1-5 жил хүртэл хугацаатай, 8.4 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.**
- **Нийт зээлийн үлдэгдлийн 52.7 хувийг хувийн хэвшилд, 46.5 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна.** Тухайн сард **олгосон зээл өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар өссөнөөс хувийн хэвшилд олгосон зээл 1.6 хувиар өсч, иргэдэд олгосон зээл 6.3 хувиар буурчээ.**
- Тухайн сард **ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-д 131.1 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 18.8 хувийн хүүтэй, 17.3 сарын хугацаатай иргэдэд олгожээ.**

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 10.9 хувиар өсч 12 их наяд 613.8 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс *татан буугдсан*¹ банкуудын зээлийн үлдэгдлийг хасч тооцвол 12 их наяд 413 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 11.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин банкуудаас *Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн*² багцыг оруулж тооцвол нийт зээлийн үлдэгдэл 15 их наяд 84 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 10.8 хувийн өсөлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 79.9 хувь төгрөгийн, 20.1 хувь валютаар олгогдсон зээл байна. Ихэнх салбаруудад төгрөгийн зээл түлхүү олгогдсон байна. Харин боловсрол, санхүү даатгал, цахилгаан, хий, уур, агааржуулалт хангамжийн салбарт валютын зээл давамгайлж байна.

Тайлант сард банкууд нийт 1.3 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон байна. Олгосон зээл өмнөх сараас 300 тэрбум төгрөгөөр буюу 29.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 5 дугаар сарын байдлаар нийт 1 их наяд 65 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн бөгөөд өмнөх сартай харьцуулахад 11.0 хувиар өссөн байна.


¹ Зоос, Хадгаламж банк.

² МИК-д шилжүүлсэн 2.46 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/



Зураг 3. Олгосон, төлөгдсөн зээл




Валютаар олгосон зээлийг авч үзвэл төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа болон усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын зээлүүд 100 хувь төгрөгөөр олгогдсон байгаа бол мэргэжлийн, шинжлэх ухаан, захиргаа, уул уурхайн салбарт дийлэнх нь гадаад валютаар олгогдсон байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 9.1 байна. Харин салбаруудаар нь авч үзвэл усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 49.7 хувь, уул уурхай олборлолт 29.2 хувь, худалдааны салбарынх 10.4 хувь, боловсруулах үйлдвэрийнх 18.5 хувьтай байна.

Нийт чанаргүй зээлийн 23.2 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 19.6 хувийг уул уурхай олборлолт, 16.1 хувийг бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Шинээр олгосон зээлийг салбаруудаар ангилан авч үзвэл 35.3 хувийг хэрэглээний зээлд, 20.6 хувийг бөөний болон жижиглэн худалдааны

Зураг 4. Олгосон зээл /төгрөг, валютаар/




Зураг 5. Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь /салбараар/

- Зээлийн бүгд дүн
- Уул уурхай, олборлолт
- Цахилгаан,хий
- Барилга
- Үл хөдлөх хөрөнгө
- Хөдөө аж ахуй
- Боловсруулах үйлдвэрлэл
- Усан хангамж
- Худалдаа
- Бусад



Зураг 6. Олгосон зээл /салбараар/

- Уул уурхай, олборлолт
- Барилга
- Бусад
- ОСИЗ
- Боловсруулах үйлдвэрлэл
- Худалдаа
- Хэрэглээний зээл




салбарт, 8.5 хувийг боловсруулах үйлдвэрт, 5.1 хувийг орон сууцны ипотекийн зээлд тус тус олгожээ.

Тайлант сард нийт олгосон зээлийн 47.4 хувийг 1 жил хүртэл хугацаатай зээл, 44.2 хувийг 1-5 жил хүртэл хугацааны зээл, 8.4 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.


Хугацаа хэтэрсэн зээлийг гол салбаруудаар авч үзвэл барилгын салбар 12.9 хувь, боловсруулах үйлдвэрт 7 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 4.4 хувь, хэрэглээний зээл 1.7 хувьтай байна.

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл захиргаа, цахилгаан хий, боловсрол, уул уурхай, олборлолтын салбарын зээл болон хэрэглээний зээл хүрэлцээтэй түвшинд байгаа бол хүний эрүүл мэнд, усан хангамж, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, төрийн удирдлагын салбар дахь уг харьцаа бага байна.

Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Зураг 8. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Зураг 9. Нийт зээлд эзлэх эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа



Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өсч 6.6 их наяд төгрөгт, иргэдийн зээл 15.6 хувиар өсч 5.8 их наяд төгрөгт тус тус хүрэв.


Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 20.9 хувь нь бөөний болон худалдааны салбарт, 20.8 хувь нь боловсруулах үйлдвэрт, 16.9 хувь нь барилгын салбарт, 10.6 хувийг уул уурхай олборлолтын салбарт ногдож байна.

МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар өсчээ.


Тайлант сард төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 19.9 хувьтай байгаа бол салбараар авч үзвэл уул уурхай 22.4 хувь, барилга 22 хувь, хэрэглээний зээл 20.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаа 20.4 хувь, хөдөө аж ахуй 20.2 хувь, боловсруулах үйлдвэр 19.2 хувь, тээвэр агуулах 19.0 хувь байна.

Иргэдийн зээлийн үлдэгдлийн 28 хувь буюу 1 их наяд 635 тэрбум төгрөг ипотекийн, 30.4 хувь буюу 1 их наяд 776 тэрбум төгрөг цалингийн, 12.2 хувь буюу 711 тэрбум төгрөг бусад зээлд,


Зураг 10. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл



Зураг 11. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт



Зураг 12. Олгосон зээлийн жилийн хүү /салбараар/



12.5 хувь буюу 733.5 тэрбум төгрөг жижиг дунд үйлдвэрийн, 11 хувь буюу 642.6 тэрбум төгрөг тэтгэврийн, 5.9 хувь буюу 346 тэрбум төгрөг хэрэглээний зээл байна.


Нийт иргэдийн зээлийн үлдэгдлийн 3.8 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харин иргэдийн ипотекийн зээлийн 3.6 хувь, цалингийн зээлийн 1.9 хувь, бусад зээлийн 3.2 хувь, хэрэглээний зээлийн 2.9 хувь, тэтгэврийн зээлийн 0.3 хувь нь чанаргүй зээл байна.


Тайлант сард иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 19.8 хувь, цалингийн зээл 20 хувь, хэрэглээний зээл 20.3 хувь, бусад зээл 21.4 хувь, тэтгэврийн зээл 17.7 хувьтай байна. Харин хугацаагаар нь авч үзвэл ипотекийн зээлийн дундаж хугацаа 18.3 жил, цалингийн зээл 3 жил, бусад зээл 1 жил, хэрэглээний зээл 1.4 жил, тэтгэврийн зээлийн хугацаа 7.4 сарын хугацаатай байна.

Тайлант сарын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 2 их наяд 81 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-д олгосон зээлийн үлдэгдлээс хамгийн өндөр 33.8 хувь буюу 455.4 тэрбум төгрөгийн зээлийг боловсруулах үйлдвэрт, 23.3 хувь буюу 313.9 тэрбум төгрөгийг худалдааны салбарт олгожээ. Харин ЖДҮ эрхлэх зориулалтаар

Зураг 13. Иргэдийн зээл /зориулалтаар/



Зураг 14. Иргэдийн чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



Зураг 15. Иргэдийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа


	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Ипотекийн зээл	11.1	219.7
Хэрэглээний зээл	20.3	17
Цалингийн зээл	20	36.6
Тэтгэврийн зээл	17.7	7.4
Бусад зээл	21.4	12

иргэдэд олгосон зээлийн бөөний болон жижиглэн худалдааны салбарт хамгийн өндөр хувь 50.9 буюу 373.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.


ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 14.7 хувь чанаргүй зээл болжээ. Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд үйлчилгээний салбарт 26.6 хувь, иргэдэд олгосон зээлийн хувьд барилгын салбарын чанаргүй зээл мөн адил өндөр буюу 28.4 хувьтай байна.

ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгогдож буй үйлчилгээний салбарын зээлийн хүү хамгийн өндөр 24.4 хувь, хугацааны хувьд 28.2 сар байна. Аж ахуйн нэгжийн барилгын салбарын хүү хамгийн өндөр 21.1 хувь, хугацааны хувьд 15.3 сар байна.

Зураг 16. ЖДҮ-ийн зээл /олгосон салбараар/



Зураг 17. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



Зураг 18. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

